

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/3/НА-СТА-ЗГТС

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр Утас: 261729 Цахим хаяг: oyuntuguldurg@audit.gov.mn Аудитор: Д.Батчимэг Утас: 261729 Цахим хаяг: batchimegda@audit.gov.mn Аудитор: Э.Булганчимэг Утас: 261729 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.5.1 Төсвийн төлөвлөлт	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	20
3.5.3 Нэмэлт төсөв	22
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	24
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	27
4.5.1 Завсрын аудитын талаар	27
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	27
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	28
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	29
5.1 Төлбөрийн акт	29
5.2 Албан шаардлага	29
5.3 Зөвлөмж	32
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	34

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЕС	Ерөнхий сайд
ЗГ	Засгийн газар
МУ	Монгол Улс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/634
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 10,614,640.6 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хичээлийн жилд суралцах 258 оюутанд 9,317,466.8 мянган төгрөгийг гэрээ байгуулаагүй олгосон;
- Гэрээний үүргээ биелүүлээгүй 1,138,679.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан 7 суралцагчтай тооцоо нийлж, эргэн төлөлтийн графикийг үйлдээгүй;
- Олон жилийн насжилттай 46,623.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй, гэрээг бүрэн дүгнээгүй;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж 46,480.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.7, 18.1, 20.2.5, 20.2.6, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3, Иргэний хуулийн 227.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 10.3, 44.1, 44.3, Засгийн

газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох журам”-ын 4.15, 11.1, 11.2, 11.2.2, Сангийн сайдын 2022 оны А/544, А/256 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Гадаадад суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох гэрээ”-ний 2.2.3 дах заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Боловсролын зээлийн сангаас олгодог тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл болон бусад санхүүгийн дэмжлэгийг шударга, нээлттэй, стандартчилагдсан байдлаар зохион байгуулах зорилгоор 2025 онд “Сонгон шалгаруулах мэдээллийн систем”-ийг анх удаа нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн байна. Өмнө нь нэгдсэн цахим системгүйгээс үүдэн бичиг баримтын алдаа, давхардал, хугацааны алдагдал, ил тод бус байдал үүсдэг байсан бол шинэ систем нэвтэрснээр бүртгэл, материалын шалгалт, үнэлгээ, оноо тооцох, дүгнэлт гаргах үе шат ил тод байдлыг хангахад чиглэсэн цахим орчин бүрдсэн байна.

Гадаад дотоодын сургалтын байгууллагад суралцсан зээлдэгчийн мэдээллийг тайлант онд Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлж, зээлийн эргэн төлөлтийн графикийг e-mongolia-д нэвтрүүлсэн. И-Монгол Академи улсын төсөвт үйлдвэрийн газрын мэдэгдэл хүргэх системийг ашиглан Монгол банкинд зээлийн мэдээлэл нийлүүлсэн талаар иргэдэд мэдээлэл илгээж, гадаад зээлээр суралцаж төгссөн 875 иргэн, хөнгөлөлттэй зээлээр суралцаж төгссөн 22,103 иргэн, давхардсан тоогоор нийт 22,860 иргэнд мэдэгдлийг хүргэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, эргэн төлүүлэх журам”-д заасны дагуу тайлант онд 1,648 гадаадын сургалтын байгууллагад суралцагчдад 67,775,933.5 мянган төгрөг, 16,807 дотоодын сургалтын байгууллагад суралцагчдад нийт 38,901,915.7 мянган төгрөгийн тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийг тус тус олгосон байна.

Зээлийн эргэн төлөлтийн хүрээнд дотоодын хөтөлбөрөөс давхардсан тоогоор 47,795 суралцагчаас 14,734,351.8 мянган төгрөг, гадаад сургалтын зээлээс 64 суралцагчаас 3,187,645.2 мянган төгрөгийн төлөлт тус тус хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сан нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Боловсролын зээлийн сантай холбогдуулан үүссэн иргэн болон захиргааны хэргийн нэхэмжлэлтэй маргаануудыг 2025 оноос хойших хугацаанд шүүхийн шатанд

хянан хэлэлцсэн байдлыг авч үзэхэд нийт 21 хэрэг бүртгэгдсэнээс 12 хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн, 9 хэрэгт нэхэмжлэлийг хангаж, 3 хэрэгт нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна. Мөн 3 хэрэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	439,352,513,795.66	522,996,659,758.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	256,053,549.12	151,932,942.91
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	256,053,549.12	151,932,942.91
31210	Төгрөг	-	150,983,314.69
31211	Төрийн сангийн харилцах	-	150,983,314.69
31220	Гадаад валют	256,053,549.12	949,628.22
31222	Монгол банк дахь харилцах	256,053,549.12	-
31223	Арилжааны банк дахь харилцах	-	949,628.22
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	58,225,796.28	19,564,336.06
32100	Үнэт цаас	58,225,796.28	19,564,336.06
32110	Төгрөг	58,225,796.28	19,564,336.06
33	АВЛАГА	269,428,558,009.12	301,615,093,695.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,663,787.05	2,941,310.52
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,578,382.58
33400	Зээлийн хүүгийн авлага	90,558.66	55,088.24
33500	Бусад авлага	46,875,495.00	46,623,500.00
33510	Байгууллагаас авах авлага	46,875,495.00	46,623,500.00
33600	Зээлийн авлага	269,376,928,168.41	301,563,895,413.90
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	269,376,928,168.41	301,563,895,413.90
33613	Сургалтын төрийн сангийн зээлийн авлага	269,376,928,168.41	301,563,895,413.90
3361301	Гадаад зээлийн авлага /19,70/	92,345,125,265.28	96,143,428,345.15
3361302	Гадаад зээлийн авлага /271/	104,080,116,364.63	145,306,570,622.62
3361303	Хөнгөлөлттэй зээлийн авлага	14,220,150,377.98	10,517,715,185.74
3361304	Оюутан хөгжлийн зээлийн авлага	58,731,536,160.52	49,596,181,260.40
34	УРЬДЧИЛГАА	169,599,625,111.14	221,207,821,804.16
34600	Урьдчилж гарсан зардал	169,599,625,111.14	221,207,821,804.16
346001	Урьдчилж гарсан зардал Магистр доктор	4,893,348,214.13	-
346002	Урьдчилж гарсан зардал Дэлхийн шилдэг	55,044,959,878.57	25,739,407,323.67
346003	Урьдчилж гарсан зардал	3,692,125,112.88	406,379,469.68
346004	Урьдчилж гарсан зардал /Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг/	62,657,296,203.73	108,459,443,064.63
346005	Урьдчилж төлсөн зардал /ЕС-ын нэрэмжит тэтгэлэг, ЗГ-ын тэтгэлэг/	13,073,822,747.58	19,617,753,340.88
346006	Урьдчилж гарсан зардал /Буцалтгүй тусламж, тэтгэлэг/	30,238,072,954.26	65,812,673,306.64
346007	Урьдчилж төлсөн зардал /ХБИ/ гадаад	-	1,172,165,298.65
35	БАРАА МАТЕРИАЛ	10,051,330.00	2,246,980.00
35400	Хангамжийн материал	10,051,330.00	2,246,980.00
35410	Бичиг хэргийн материал	1,154,050.00	1,565,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	8,750,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	147,280.00	681,280.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	289,182,019.54	214,230,613.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	289,182,019.54	214,230,613.46
39200	Биет хөрөнгө	160,069,192.99	115,495,806.95
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	189,148,635.00	189,148,635.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(68,947,806.98)	(106,334,994.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,361,847.00	65,361,847.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,493,482.03)	(32,679,680.61)

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

39300	Биет бус хөрөнгө	129,112,826.55	98,734,806.51
39301	Программ хангамж	245,280,200.00	245,280,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(116,167,373.45)	(146,545,393.49)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	439,641,695,815.20	523,210,890,371.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.08	3,965,882.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.08	3,965,882.60
41300	Өглөг	0.08	3,965,882.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.08	1,000.02
41360	Бусад өглөг	-	3,964,882.58
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	3,964,882.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	439,641,695,815.12	523,206,924,489.23
51	Засгийн газрын хувь оролцоо	439,641,695,815.12	523,206,924,489.23
51100	Засгийн газрын оруулсан капитал	29,809,531.00	29,809,531.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	29,809,531.00	29,809,531.00
51200	Хуримтлагдсан үр дүн	439,611,886,284.12	523,177,114,958.23
51210	Өмнөх үеийн үр дүн	358,311,021,102.77	439,627,413,221.64
51220	Тайлант үеийн үр дүн	81,300,865,181.35	83,549,701,736.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	439,641,695,815.20	523,210,890,371.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	106,161,818,116.95	90,064,835,594.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	497,519,801.45	90,064,835,594.93
120	Нийтлэг татварын бус орлого	497,519,801.45	443,912,236.24
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	434,550,001.45	443,912,236.24
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	434,550,001.45	443,912,236.24
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	62,969,800.00	-
122	Тусламжийн орлого	-	89,620,923,358.69
1221	Хандив тусламж /дотоод/	-	89,620,923,358.69
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	89,607,123,358.69
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	89,607,123,358.69
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	13,800,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,664,298,315.50	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	105,664,298,315.50	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,664,298,315.50	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	25,147,244,747.24	6,542,360,407.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,147,244,747.24	6,542,360,407.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,680,729,390.50	1,706,541,154.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,077,313,123.54	1,161,989,420.65
210101	Үндсэн цалин	687,161,410.47	637,274,675.61
210102	Нэмэгдэл	179,327,019.71	257,579,915.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,854,590.91	189,472,000.00
210104	Урамшуулал	89,970,102.45	77,662,829.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,290,969.57	146,424,396.71
210201	Тэтгэврийн даатгалын зардал	95,427,716.23	101,856,682.43
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	11,100,618.54	11,559,534.65
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,408,409.37	5,719,755.48
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	5,081,188.08	5,457,684.65
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	20,273,037.35	21,830,739.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	276,032,561.55	205,322,406.66
210304	Байрны түрээс	276,032,561.55	205,322,406.66
2104	Хангамж, бараа материалын зардал	26,767,685.74	35,588,934.00
210401	Бичиг хэрэг	7,112,950.00	15,603,950.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,277,565.74	13,795,634.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,977,170.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	6,189,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,065,800.00	550,350.00
210604	Урсгал засвар	1,065,800.00	550,350.00
2107	Томилолт, зочны зардал	338,900.00	-
210702	Дотоод албан томилолт	338,900.00	-

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,044,275.00	81,714,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,520,275.00	41,464,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,524,000.00	40,249,740.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,876,075.10	74,951,406.08
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,876,075.10	74,951,406.08
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,466,515,356.74	4,835,819,253.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	425,821,375.33
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	425,821,375.33
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	425,821,375.33
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	65,409,453.68
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	161,279,948.70
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	11,815,334.95
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	187,316,638.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,537,362,055.90	4,409,997,877.69
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,502,915,091.68	4,409,997,877.69
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,166,964.22	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,929,153,300.84	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	911,013,295.86	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,921,661.95	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	15,016,218,343.03	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	81,014,573,369.71	83,522,475,187.81
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	649,231,583.24	31,438,459.80
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	649,231,583.24	31,438,459.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	362,939,771.60	4,211,911.02
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	46,666.38	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	362,893,105.22	4,211,911.02
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	286,291,811.64	27,226,548.78
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	81,300,865,181.35	83,549,701,736.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	120,919,952,281.30	90,674,169,777.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	696,884,863.89	90,674,169,777.11
120	Нийтлэг татварын бус орлого	696,884,863.89	1,041,431,083.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	696,884,863.89	1,041,431,083.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,041,431,083.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	696,884,863.89	-
122	Тусламжийн орлого	-	89,632,738,693.64
1221	Хандив тусламж /дотоод/	-	89,632,738,693.64
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	89,607,123,358.69
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	89,607,123,358.69
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	25,615,334.95
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,800,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,815,334.95
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	120,223,067,417.41	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	120,221,145,755.46	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	105,664,298,315.50	-
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	14,556,847,439.96	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,921,661.95	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,921,661.95	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,315,515,749.35	92,524,909,050.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,315,515,749.35	92,524,909,050.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,667,505,690.47	1,621,809,926.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,079,602,446.52	1,160,504,769.66
210101	Үндсэн цалин	692,976,559.71	635,927,643.64
210102	Нэмэгдэл	177,844,522.64	257,756,046.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	120,194,092.61	189,409,102.49
210104	Урамшуулал	88,587,271.56	77,411,976.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	137,342,286.31	146,185,571.23
210201	Тэтгэврийн даатгалын зардал	95,455,874.40	101,480,886.71
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	11,194,129.31	11,742,499.47
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	5,399,064.73	5,705,589.68
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	5,071,843.84	5,451,519.05
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	20,221,374.03	21,805,076.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	302,075,096.90	205,322,406.66
210304	Байрны түрээс	302,075,096.90	205,322,406.66
2104	Хангамж, бараа материалын зардал	28,321,010.74	36,282,589.00

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	8,267,000.00	16,015,600.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,529,560.74	13,543,639.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,124,450.00	6,723,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,065,800.00	550,350.00
210604	Урсгал засвар	1,065,800.00	550,350.00
2107	Томилолт, зочны зардал	338,900.00	-
210702	Дотоод албан томилолт	338,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,760,150.00	72,964,240.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,486,150.00	41,464,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,274,000.00	31,499,740.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,648,010,058.88	90,903,099,124.13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	427,399,757.91
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	427,399,757.91
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	427,399,757.91
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	65,409,453.68
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	161,279,948.70
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	11,815,334.95
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	187,316,638.00
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	1,578,382.58
2132	Бусад урсгал шилжүүлэг	86,713,459,174.31	90,475,699,366.22
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,679,012,210.09	90,475,699,366.22
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,166,964.22	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	280,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,934,550,884.57	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	911,013,295.86	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,921,661.95	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	15,021,615,926.76	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,604,436,531.95	(1,850,739,273.57)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	69,884,180.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	69,884,180.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	69,884,180.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	69,884,180.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(69,884,180.00)	-
14	Бусад эх үүсвэр	40,746,660.47	17,947,163,344.13
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх	-	17,921,996,961.75
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	40,746,660.47	25,166,382.38

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	16,319,245,463.30	16,196,332,765.75
230001	Эргэж төлөгдөх зээл	16,319,245,463.30	16,196,332,765.75
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	4,211,911.02
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	4,211,911.02
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(16,278,498,802.83)	1,746,618,667.36
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	256,053,549.12	(104,120,606.21)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	256,053,549.12
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	256,053,549.12	151,932,942.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	29,809,531.00	301,175,256,925.59	301,205,066,456.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	57,135,764,177.18	57,135,764,177.18
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	358,311,021,102.77	358,340,830,633.77
9	Тайлант үеийн үр дүн	-	81,300,865,181.35	81,300,865,181.35
10	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	29,809,531.00	439,611,886,284.12	439,641,695,815.12
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	15,526,937.52	15,526,937.52
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	439,627,413,221.64	439,657,222,752.64
19	Тайлант үеийн үр дүн	-	83,549,701,736.59	83,549,701,736.59
20	2025 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	29,809,531.00	523,177,114,958.23	523,206,924,489.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	124,264,574,800.00	90,401,645,388.81	33,862,929,411.19	72.7
12	Татварын бус орлого	124,264,574,800.00	90,401,645,388.81	33,862,929,411.19	72.7
120	Нийтлэг татварын бус орлого	-	859,931,483.80	(859,931,483.80)	100.0
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	-	859,931,483.80	(859,931,483.80)	100.0
122	Тусламжийн орлого	124,264,574,800.00	89,541,713,905.01	34,722,860,894.99	72.1
122005	Төсвөөс санхүүжих	124,264,574,800.00	89,541,713,905.01	34,722,860,894.99	72.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	127,868,774,800.00	90,363,862,135.10	37,504,912,664.90	70.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	129,936,077,900.00	92,089,527,048.38	37,846,550,851.62	70.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,638,428,700.00	1,608,009,926.55	30,418,773.45	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,172,001,000.00	1,160,504,769.66	11,496,230.34	99.0
210101	Үндсэн цалин	567,821,600.00	635,927,643.64	(68,106,043.64)	112.0
210102	Нэмэгдэл	378,238,100.00	257,756,046.72	120,482,053.28	68.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	137,894,500.00	189,409,102.49	(51,514,602.49)	137.4
210104	Урамшуулал	88,046,800.00	77,411,976.81	10,634,823.19	87.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,667,600.00	146,185,571.23	18,482,028.77	88.8
210201	Тэтгэврийн даатгал	118,099,400.00	101,480,886.71	16,618,513.29	85.9
210202	Тэтгэмжийн даатгал	11,658,500.00	11,742,499.47	(83,999.47)	100.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,822,600.00	5,705,589.68	117,010.32	98.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,817,400.00	5,451,519.05	365,880.95	93.7
210205	Эрүүл мэндийн даатгал	23,269,700.00	21,805,076.32	1,464,623.68	93.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,322,500.00	205,322,406.66	93.34	100.0
210304	Байрны түрээс	205,322,500.00	205,322,406.66	93.34	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,282,600.00	35,282,589.00	11.00	100.0
210401	Бичиг хэрэг	13,241,900.00	15,015,600.00	(1,773,700.00)	113.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,838,800.00	13,543,639.00	2,295,161.00	85.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,201,900.00	6,723,350.00	(521,450.00)	108.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	550,400.00	550,350.00	50.00	100.0
210604	Урсгал засвар	550,400.00	550,350.00	50.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,604,600.00	60,164,240.00	440,360.00	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,664,500.00	28,664,500.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,940,100.00	31,499,740.00	440,360.00	98.6

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,297,649,200.00	90,481,517,121.83	37,816,132,078.17	70.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,297,649,200.00	90,481,517,121.83	37,816,132,078.17	70.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	128,297,649,200.00	90,481,517,121.83	37,816,132,078.17	70.5
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(2,067,303,100.00)	(1,725,664,913.28)	(341,638,186.72)	83.5
230001	Эргэж төлөгдөх зээл	(2,067,303,100.00)	(1,725,664,913.28)	(341,638,186.72)	83.5
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,604,200,000.00)	37,783,253.71	(3,641,983,253.71)	(1.0)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,604,200,000.00	(37,783,253.71)	3,641,983,253.71	(1.0)
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	3,604,200,000.00	(37,783,253.71)	3,641,983,253.71	(1.0)
	Ханшийн зөрүүний олз	-	19,376,088.78	(19,376,088.78)	(100.0)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	256,053,549.12	(256,053,549.12)	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	151,932,942.91	(151,932,942.91)	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32	32	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	31	31	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	25,615,334.95
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	25,615,334.95
122	Тусламжийн орлого	-	25,615,334.95
1221	Хандив тусламж /дотоод/	-	25,615,334.95
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	25,615,334.95
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	13,800,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	11,815,334.95
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	13,800,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	13,800,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	13,800,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	-	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	12,800,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	12,800,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	11,815,334.95
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(11,815,334.95)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(11,815,334.95)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын зээлийн сан нь Дотоод, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зохих журмын дагуу сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламж олгох, Багш суралцагчид төрөөс дэмжлэг зээлийг эргэн төлүүлэх, сангийн хөрөнгийг бүрдүүлж, төвлөрүүлэн зарцуулах, тайлагнах чиг үүрэгтэй.

Боловсролын зээлийн сан нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Зорилготой, хариуцлагатай оюутан суралцагчдад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг шуурхай хүргэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр суралцаж байгаа, зээлийн шалгуур хангасан Монгол Улсын иргэнд “Оюутны хөгжлийн зээл” олгох, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах;
- Гадаад улс оронд суралцах оюутан, суралцагчид сургалтын зээл олгох, Гадаад улсад суралцаж төгссөн оюутан, суралцагчдыг сургалтын зээлийн төлбөрөөс чөлөөлөх, эргэн төлүүлэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох;
- Засгийн газрын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох;
- Буцалтгүй тусламж, тэтгэлэг олгох.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын зээлийн сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дах хэсгийг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам” шинэчлэн батлагдсан;

- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлагдаж, 2025 оноос даган мөрдөж байна;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг "Боловсролыг дэмжих жил" болгон зарласан;
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/253, А/123 дугаар тушаалаар "Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журам" батлагдсан.

Сангийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Салбарын яамнаас тусгай сангаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлсэн тайлан, дүгнэлт байхгүй боловч "Боловсролын зээлийн сангийн 2017-2024 оны үйл ажиллагааны үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, биелэлтийг дүгнэн нэгтгэн 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхээр төлөвлөн ажилласан байна.

Боловсролын сайдын 2025 оны А/273, А/50 дугаар тушаалаар гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад 2025-2026 оны хичээлийн жилээс буцалтгүй тусламжаар суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон Засгийн газрын хоорондын гэрээний дагуу гадаад улсад суралцах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын дэргэд сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн өргөдөл, гомдолд хариу өгөх, олон нийтийн оролцоог хангах, нээлттэй, ил тод, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажилладаг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Боловсролын зээлийн сангийн Ажлын алба нь дотоод аудитын нэгжгүй, дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэнтэй бөгөөд 2025 онд 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөгөө батлуулснаас тайлант онд байгууллагын, хэлтсийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, сар, улирал, жилийн тайлан, бүтэц, орон тоо, чиг үүрэг зэрэгт шинжилгээ, дүгнэлт хийж, зөвлөмж өгч ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сан нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч 2021 оноос хойш өөрчлөлт ороогүй.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөд өмнөх онд хийгдээгүй байсан 15,526.9 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүг бүртгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83,569,194.6 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өсжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	256,053.6	151,932.9	(104,120.7)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	58,225.8	19,564.4	(38,661.4)
Авлага	269,428,558.0	301,615,093.7	32,186,535.7
Урьдчилгаа	169,599,625.1	221,207,821.8	51,608,196.7
Бараа материал	10,051.3	2,247.0	(7,804.3)
Үндсэн хөрөнгө	289,182.0	214,230.6	(74,951.4)
Нийт хөрөнгө	439,641,695.8	523,210,890.4	83,569,194.6
Өр төлбөр	0.0	3,965.9	3,965.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	439,641,695.8	523,206,924.5	83,565,228.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	439,641,695.8	523,210,890.4	83,569,194.6

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Жилийн эцэст төрийн сан дахь төгрөгийн дансанд 480 суралцагчийн оюутны хөгжлийн зээл болон хөнгөлөлттэй зээлийн 150,453.3 мянган төгрөг, 5 суралцагчийн хөнгөлөлттэй зээлийн 530.0 мянган төгрөг, 1 суралцагчийн

гадаадын зээлийн 949.6 мянган төгрөгийн эргэн төлөлтөөс шалтгаалж мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 151,932.9 мянган төгрөг болсон байна.

- Богино хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 38,661.4 мянган төгрөгөөр буюу 66.4 хувиар буурсан нь 2016-2017 онуудад арилжааны 4 банкаар дамжуулан олгосон хөнгөлөлттэй зээлийг жилийн 2 хувийн хүүтэй энгийн векселиэр бүртгэж, зээлийн эргэн төлөлт хийгдсэнтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 32,186,535.7 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн нь гадаад зээлийн авлага 45,024,757.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, оюутан хөгжлийн зээлийн авлага 9,135,354.9 мянган төгрөгөөр, хөнгөлөлттэй зээлийн авлага 3,702,435.2 мянган төгрөгөөр тус тус хорогдсон нь голлох нөлөөг үзүүлсэн байна.
- Урьдчилгаа дансны үлдэгдэл 51,608,196.7 мянган төгрөгөөр буюу 30.4 хувиар өссөн нь нөхцөл заасан буцалтгүй тусламж, тэтгэлэгт 35,574,600.4 мянган төгрөг, ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 45,802,146.9 мянган төгрөг, засгийн газрын нэрэмжит тэтгэлэгт 6,543,930.6 мянган төгрөг, гадаадад суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 1,172,165.3 мянган төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэж, 37,484,646.4 мянган төгрөгийг дансны авлагын дансанд бүртгэснээс шалтгаалсан байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 7,804.3 мянган төгрөгөөр буюу 77.6 хувиар буурсан нь тайлант онд зарцуулсан сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материалтай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 74,951.4 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан нь тайлант онд байгуулагдсан машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, программ хангамжийн элэгдлийн зардалтай холбоотой байна.
- Өр төлбөрийн данс 3,965.9 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар өссөн нь хувь хүмүүст төлөх өглөгөөс шалтгаалсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 83,565,228.7 мянган төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн нь өмнөх онд тооцоогүй байсан 15,526.9 мянган төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүү болон тайлант оны үр дүн 83,549,701.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Тус сангийн биет бус хөрөнгөнд 243,920.2 мянган төгрөгийн балансын үнэтэй хэрэглээний 8 ширхэг оюутан хөгжлийн зээл, зорилтот алба, гадаад зээл, тэтгэлэгтэй холбоотой программ, 1,360.0 мянган төгрөгийн балансын үнэтэй санхүүгийн программ бүртгэлтэй байна. Өмнөх аудитаар ашиглалтгүй байгаа 94,800.0 мянган төгрөгийн 2 программ хангамжийг ТӨБЗГ-т хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх зөвлөмжийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/12 гэсэн албан бичгээр данснаас хасах зөвшөөрөл авахаар ТӨБЗГ-т хүргүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 227,257,394.1 мянган төгрөг, нийт зарлагыг 227,257,394.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 5211 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 68,826,678.3 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 158,430,715.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайлбал, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллыг 49,967,357.5 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлээс зарцуулах эрхийг 17,719,189.1 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,140,131.7 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Мөн төсвийн тодотголоор нийт зардлыг 561,941.0 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна. Төсөв захирагчийн хэрэгжүүлэх “Дээд боловсрол” хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 124,264,574.8 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 33,604,200.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлэхээр баталсан байна.

Төсвийн төлөвлөлтийн тухайд төсөв захирагчийн саналыг харгалзан үзэлгүйгээр батлагдсан төсвийг бууруулсан, мөн батлагдсан төсвийн тодорхой хэсэгт Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавартай холбогдуулан санхүүжилтийн эрх нээгээгүй байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны гүйцэтгэлээр улсын төсвөөс 89,541,713.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зээлийн эргэн төлөлт болон бусад эх үүсвэрээс 859,931.5 мянган төгрөг бүрдүүлж, 90,363,862.1 мянган төгрөг зарцуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 90,363,862.1 мянган төгрөг буюу 70.7 хувьтай байгаа нь Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээс 9,365,666.1 мянган төгрөг, Оюутны хөгжлийн зээлээс 7,674,582.6 мянган төгрөг, МУ-ын Засгийн газрын тэтгэлгээс 6,637,438.2 мянган төгрөг, Зорилтот бүлгийн суралцагчдад олгох буцалтгүй тусламжаас 6,187,550.3 мянган төгрөг, Зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчдад олгох тэтгэлгээс 4,968,960.2 мянган төгрөг, ЗГ-н гэрээгээр гадаадад суралцагсдын тэтгэлгээс 4,374,357.0 мянган төгрөг, Гадаадад суралцагсдын зээлээс 4,061,782.3 мянган төгрөг, Орон нутгийн их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн хөнгөлөлтөөс 2,712,196.1 мянган төгрөг, Багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магиструудад олгох сургалтын төлбөрөөс 2,045,120.0 мянган төгрөг, Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгээс 1,085,366.0 мянган төгрөг, ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлгээс 312,009.2 мянган төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад олгох буцалтгүй тусламжаас 127,445.0 мянган төгрөг, Үндсэн үйл ажиллагааны зардлаас 30,418.8 мянган төгрөг, Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлгээс 23.9 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Бие-лэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,624,764.2	1,594,345.4	30,418.8	98.1
2	81569 Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	13,664.5	13,664.5	-	100.0
Нийт үндсэн үйл ажиллагаа		1,638,428.7	1,608,009.9	30,418.8	98.1
3	81812 ЗГ-ын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг	2,436,482.8	2,124,473.6	312,009.2	87.2
4	81813 Зорилтот бүлгийн суралцагчдад олгох буцалтгүй тусламж	8,480,145.9	2,292,595.6	6,187,550.3	27.0
5	81820 Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлэг	4,153,513.3	3,068,147.3	1,085,366.0	73.9
6	81826 Багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магиструудад олгох сургалтын төлбөр	24,641,311.5	22,596,191.5	2,045,120.0	91.7
7	81828 Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг	23.9	-	23.9	-
8	81849 Зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчдад олгох тэтгэлэг	9,264,492.4	4,295,532.2	4,968,960.2	46.4
9	81852 ЗГ-н гэрээгээр гадаадад суралцагсдын тэтгэлэг	5,714,038.4	1,339,681.4	4,374,357.0	23.5
10	81853 Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	56,234,768.5	46,869,102.4	9,365,666.1	83.4
11	81854 МУ-ын Засгийн газрын тэтгэлэг	13,464,807.0	6,827,368.8	6,637,438.2	50.7
12	81869 Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад олгох буцалтгүй тусламж	1,195,869.4	1,068,424.4	127,445.0	89.3
13	81872 Орон нутгийн их дээд сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн хөнгөлөлт	2,712,196.1	-	2,712,196.1	-
Нийт буцалтгүй тусламж, тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлт		128,297,649.2	90,481,517.1	37,816,132.1	70.5
14	81846 Оюутны хөгжлийн зээл	9,907,154.9	2,232,572.3	7,674,582.6	22.5
15	81851 Гадаадад суралцагсдын зээл	18,025,542.0	13,963,759.7	4,061,782.3	77.5
Нийт зээл		27,932,696.9	16,196,332.0	11,736,364.9	58.0
16	81404 Дамжуулан зээлдүүлсэн зээл	(30,000,000.0)	(17,921,997.0)	(12,078,003.0)	59.7
Нийт		127,868,774.8	90,363,862.1	37,504,912.6	70.7

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй, 32 орон тоотой ажилласан байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 2025 онд төсвөөр 1,172,001.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 1,160,504.8 мянган төгрөг байна.
- Нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны зардал 30.0 мянган төгрөг, унааны зардал 2.0 мянган төгрөг байхаар Боловсролын зээлийн сангийн ажлын албаны

даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн "Албан хаагчдын цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/01 дүгээр тушаалаар баталсан байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөв 137,894.5 мянган төгрөгөөр батлагдаж, 189,409.1 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

- Гадаад томилолтын зардал батлагдаагүй.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэсэн заалтыг тайлант онд хэрэгжүүлэн ажилласан байна.
- Тайлант онд хэвлэл, мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ байхгүй.
- Ажлын албаны даргын 2024 оны Б/23 дугаар тушаалыг үндэслэн чөлөөлөгдсөн ажилтанд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 12,571.8 мянган төгрөгийг урсгал зардлаас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг тайлант онд авч ажиллаагүй асуудалд албан шаардлага хүргүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус сан нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 13,800.0 мянган төгрөг, төсөв болон дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх 11,130.0 мянган төгрөг, арилжааны 4 банкны энгийн векселийн хүүгийн орлого 685.4 мянган төгрөгийг бүрдүүлж, үйл ажиллагаанд 13,800.0 мянган төгрөгийг зарцуулж, нийт 11,815.3 мянган төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Боловсролын зээлийн сан, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор гэрээний үүргийн биелэлт, гэрээ байгуулах, эргэн төлөлтийн хуваарь үйлдэх, НБББББ-ийн дагуу бүртгэл хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитор Д.Батчимэг, Э.Булганчимэг нар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Их” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,546,572.3 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 32,732.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор төсөв захирагч төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах дараах арга хэмжээг авч ажилласан байна. Тухайлбал:

- Багаж хэрэгсэл, тавилга, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, гадаад, дотоод томилолт, ажил олгогчоос олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, хог хаягдал зайлуулах, нормын хувцас худалдан авах зардал, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах зардал батлагдаагүй.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэх хүрээнд шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал нөөцлөхгүй байх арга хэмжээг авч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.
- Тайлант онд 427,399.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн бодлого, ажлын албаны чиг үүрэгтэй холбоотой нийт 7 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсрол зээлийн сан нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулбал зохих 21 нэр төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Зөвлөмж

Илрүүлэлт 1. Сангийн хөрөнгөөр гадаадад тэтгэлэг, зээлээр суралцсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 2025 оны байдлаар гаргаагүй, суралцагч, төгсөгчийг дэмжих зорилгоор ажил олгогчидтой уулзах өдөрлөгийг заасан хугацаанд зохион байгуулаагүй, ажлын байрны захиалгын сан бүрдүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. "Төрийн албаны стандарт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно", БШУС-ын 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/256 дугаар тушаалаар баталсан "Боловсролын зээлийн сангийн ажлын албаны ажиллах журам"-ын 2.2.9."сангийн хөрөнгөөр суралцсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргах, суралцагч, төгсөгчийг дэмжих зорилгоор ажил олгогчидтой уулзах өдөрлөгийг жил бүрийн III улиралд, шаардлагатай тохиолдолд тогтоосон хугацаанд зохион байгуулах, ажлын байрны захиалга ирүүлсэн байгууллагатай холбох, ажлын байрны захиалгын сан бүрдүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг гаргах, суралцагч, төгсөгчийг дэмжих зорилгоор ажил олгогчидтой уулзах өдөрлөгийг журамд заасан хугацаанд зохион байгуулах, ажлын байрны захиалгын сан бүрдүүлэх.

Илрүүлэлт 2. Боловсролын зээлийн сангийн ажлын албаны дарга нь ЗГ хоорондын гэрээний дагуу МУ-аас гадаад улсад 2025-2026 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулах, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад буцалтгүй тусламжаар суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг ахалсан нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 72 дугаар тогтоолоор батлагдсан "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын 2.2."Сангаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.1-д заасан иргэнд сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг олгох, мөн хуулийн 8.3-т заасны дагуу бусад санхүүгийн дэмжлэг олгох шийдвэрийг Ажлын хэсгийн сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана", БШУС-ын 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/256 дугаар тушаалаар баталсан "Боловсролын зээлийн сангийн ажлын албаны ажиллах журам"-ын 2.2.1."эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу зохион байгуулсан холбогдох сонгон шалгаруулалтын шийдвэрийг үндэслэн Боловсролын зээлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл олгох, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, холбогдох хууль журамд заасан бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах", 2.2.2 "энэхүү журмын 2.2.1-д заасан асуудлаар суралцагчтай гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах, гэрээг сунгах, дуусгавар болгох", 3.2.8 "Ажлын албыг төлөөлж суралцагчтай гэрээ байгуулах, холбогдох журамд заасан үндэслэлээр гэрээг түтгэлзүүлэх, сунгах, дуусгавар болгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын албаны дарга нь сонгон шалгаруулах ажлын хэсгийг ахлахгүй байх .

Илрүүлэлт 3. Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь тайлант онд дээд шатны төсөв захирагчаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан боловч Төсвийн тухай хуульд заасны дагуу үр дүнгийн гэрээ байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1. "Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна", 40.3. "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Илрүүлэлт 4. Засгийн газрын 2021 оны "Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 264 дүгээр тогтоолоор ажлын албаны орон тооны хязгаарыг 32 байхаар тогтоосон бөгөөд 2025 онд 13 албан хаагч шинээр томилогдож, 8 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөнийг нийт орон тоонд харьцуулахад 25 хувь нь чөлөөлөгдөж, 40.6 хувь нь шинээр томилогдсон үзүүлэлтээс дүгнэхэд ажлын албанд хүний нөөцийн бодлого сул хэрэгжиж, шилжилт хөдөлгөөн өндөр байгаа нь хүний

нөөцийн мэргэшсэн, тогтвортой байх зарчим алдагдаж улмаар төрийн үйлчилгээ иргэдэд чанартай, хүртээмжтэй, үр нөлөөтэй хүргэхэд эрсдэл учруулж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1."Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараах зарчмыг баримтална: 7.1.2.мэргэшсэн, тогтвортой байх", БШУС-ын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/256 дугаар тушаалаар баталсан "Боловсролын зээлийн сангийн ажлын албаны ажиллах журам"-ын 3.2.4."хууль, эрх зүйн бусад баримт бичигт нийцүүлэн ажилтныг томилох, чөлөөлөх, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, бусад үндэслэлээр дуусгавар болгох, хөдөлмөрийн гэрээ байгуулах, өөрчлөх, дуусгавар болгох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажлын албаны хүний нөөцийг мэргэшсэн, тогтвортой ажиллуулахад анхаарч, хүний нөөцийн хөдөлгөөнийг 2025 оны үзүүлэлтээс нэмэгдүүлэхгүй байх.

Илрүүлэлт 5. Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2025 оны А/90 дүгээр тушаалаар Албан тушаалын тодорхойлолтыг батлахдаа зарим ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулахгүйгээр "мэргэжил" гэсэн шаардлагад олон төрлийн мэргэжлийг тусгасан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5."албан тушаалын тодорхойлолт" гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан тушаалын тодорхойлолтыг ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулан боловсруулж, батлах.

Илрүүлэлт 6. Ажлын алба нь тайлант оны III, IV улиралд тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар суралцаж байгаа суралцагчдын гэрээг хугацаанд нь дүгнэж, үнэлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-ын 12.3.5."гэрээний биелэлтэд хяналт тавих, улирал тутам үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулах", 12.3.6."гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан санхүүжилтийг зогсоох, суутгах, эргэн төлүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар суралцаж байгаа суралцагчдын гэрээг хугацаанд нь дүгнэж, үнэлэх.

Илрүүлэлт 7. Ажлын алба нь захиргааны үйл ажиллагаанаас бусад баримт бичгийг цахим хэлбэрээр архив үүсгээгүй, мөн суралцагчдын хувийн хэргийг журмын дагуу цахимжуулж хадгалаагүй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 3.1."Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 3.1.1.арга зүйн хувьд нэгдмэл байх, 3.1.2.бүрдүүлэлт тогтмол, бүрэн байх"; БШУС-ын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/256 дугаар тушаалаар баталсан "Боловсролын зээлийн

сангийн ажлын албаны ажиллах журам"-ын 6.4."Ажлын албаны үйл ажиллагаа, зарцуулалттай холбоотой бүх баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу жил бүр цаасан, цахим хэлбэрээр архивын хадгаламжийн нэгж үүсгэж, хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу мөрдөж ажиллана", Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-ын 13.6."Сан суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаа бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад)-ийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Захиргааны үйл ажиллагаанаас бусад баримт бичиг, суралцагчдын хувийн хэргийг журмын дагуу цахимжуулж, хадгалах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулж, төлөвлөгөөг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 01/164 дүгээр албан бичгээр төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Боловсролын зээлийн сангийн 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01/826 дугаар албан бичгээр аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний явцын биелэлт, 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 01/51 дугаар албан бичгээр жилийн эцсийн тайлан, нотлох баримтыг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар нийт 201,694,811.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 201,600,011.4 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 94,800.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна. Өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт нотлох баримттай тулган шалгаж 99.9 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	7	201,600,011.4	7	201,495,373.7	99.9
Зөвлөмж	1	94,800.0	1	94,800.0	100.0
Нийт дүн	8	201,694,811.4	8	201,590,173.7	99.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар сангаас зээл авсан суралцагчдын барьцааны зүйлд анхаарал хандуулж горим, сорил хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Төсвийн шууд захирагчийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасны дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч тус хавсралтад тусгагдсан санхүүгийн тайлан бэлтгэх маягтууд болон “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем”-д шивж буй тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байна. Иймд журмаар батлагдсан маягт болон нэгдсэн системийн тайлангийн үзүүлэлтийн зөрүүг арилгаж нэгдсэн ойлголтоор санхүүгийн тайлан бэлтгэсэн эсэх.
- Боловсролын зээлийн сангийн эрх зүйн зохицуулалтыг салбарын хуультай уялдуулж, хяналт-шинжилгээ, эргэн төлөлтийн механизмыг сайжруулан ил тод, хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна. Иймд эрх зүйн шинэчлэлийг шуурхай хэрэгжүүлэх нь сангийн үр ашиг, хүний нөөцийн хөгжлийн үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.
- Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Засгийн газрын Чевнинг тэтгэлэгт хөтөлбөрийн дагуу 2025-2026 оны хичээлийн жилд магистрын хөтөлбөрт суралцах суралцагчдын нэрсийг 2025.10.28-ны өдрийн А/515 дугаар тушаалаар баталсан боловч Засгийн газар хооронд 2022 онд байгуулсан гэрээний сунгалт хийгдээгүйтэй холбоотой 15 суралцагчийн гэрээ байгуулагдаагүй, санхүүжилт хийгдээгүй.
- Боловсролын зээлийн сангийн ашиглаж буй цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, нэгдсэн мэдээллийн систем бий болгоход шаардлагатай төсөв, хөрөнгийн санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх, сангийн төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, үр дүнтэй, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх талаар бодлогын шийдвэр гаргах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 295,049.6 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад 295,049.6 мянган төгрөгийн 3 алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 284,554.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан;
- Гадаад валютын ханшийн зөрүүний олзыг 6,272.1 мянган төгрөгөөр дутуу, Гадаад валютын ханшийн зөрүүний гарзыг 2,151.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнгээс 2,071.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 10,614,640.6 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрсэнд, 10,585,862.7 мянган төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага хүргүүлж, 28,777.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 10,614,640.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 32,732.9 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

Урьдчилгаа, авлагын данстай холбоотой

Илрүүлэлт 1: Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хичээлийн жилд суралцах 258 оюутанд 9,317,466.8 мянган төгрөгийг гэрээ байгуулаагүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна", Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-ын 4.15-д "Сан бэлтгэл хөтөлбөрт шалгарсан суралцагч болон суралцах сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, үндсэн хөтөлбөрийн суралцагч болон түүний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ, энэ журмын 4.2.2-т заасан суралцагчтай хоёр талт гэрээг тус тус байгуулна", 11.1-д "Сан нь суралцагчтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулна. Суралцагчтай байгуулах гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална", 11.2-т "Суралцагчтай байгуулах гэрээг хичээлийн улирлын үргэлжлэх хугацаагаар байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана: 11.2.2. зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хэмжээ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн 2025-2026 оны хичээлийн жилд Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах 258 оюутантай гэрээ байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2: Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/480, 2023 оны А/408 дугаар тушаалын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд гадаадад суралцаж байсан 7 суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тул санхүүжилтийг зогсоосон боловч тус суралцагчидтай тооцоо нийлж, эргэн төлүүлэх графикийг үйлдээгүй байна. Эдгээр суралцагчдад дотоодын бэлтгэл хөтөлбөрт 30,441.3 мянган төгрөг, сургалтын төлбөр, дотуур байр, амьжиргааны зардалд 1,108,237.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.1-д "Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2022 оны А/544, А/256 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Гадаадад суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох гэрээ"-ний 2.2.3-т "Санхүүжилт олгох хугацаанд хамаарах дүнгийн мэдээллийг хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд тухайн оронд суугаа Монгол Улсын Элчин сайдын яам болон Санд хүргүүлнэ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үүргээ биелүүлээгүй 7 суралцагчидтай тооцоо нийлж, эргэн төлүүлэх хуваарийг үйлдээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 3: "Наргил шийдэл" ХХК-тай 46,623.5 мянган төгрөгийн мэдээллийн технологийн шийдлийг бүтээх, зөвлөгөө өгөхөөр хамтран ажиллах гэрээг 2020 онд байгуулсан боловч одоог хүртэл гэрээг бүрэн дүгнээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8."төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар

зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээг бүрэн дүгнээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 4: Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэгтэй ажлын албаны дэргэдэх орон тооны бус зөвлөлөөс зохих хяналтыг тавьж ажиллаагүйгээс Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтаагүй University of latin American, Istanbul Technical University сургуулиудаас хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй хүний их эмч болон сүлжмэлийн инженер мэргэжлээр тус тус урилга авсан 2 иргэнийг сонгон шалгаруулж, 23,841.5 мянган төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 дугаар зарлигийн 1-д "Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтсан сургуульд суралцагчид хүсэлтийг нь үндэслэн суралцаж буй мэргэжлийн чиглэлийг харгалзахгүйгээр санхүүжилт олгох", 2-т "Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн 21-100-д багтсан сургуульд суралцагчид Монгол Улсын Засгийн газраас зарласан мэргэжлийн чиглэлийг харгалзан хүсэлтийг нь үндэслэн санхүүжилт олгох", Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай" 115 дугаар тогтоол "хавсралт 1-д заасан мэргэжлийн чиглэл", Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Орон тооны бус зөвлөлийн ажиллах дүрмийг батлах тухай" тушаалын 2.9.1-д "сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэгтэй ажлын албаны дэргэдэх орон тооны бус зөвлөлөөс дүрэмд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Нийт зардалтай холбоотой

Илрүүлэлт 5: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж 46,480.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны

төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 6: Ажлын албаны даргын 2024 оны Б/23 дугаар тушаалыг үндэслэн чөлөөлөгдсөн ажилтанд дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 12,571.8 мянган төгрөгийг байгууллагаас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг тайлант онд авч ажиллаагүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 4.2.9. энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлага, урьдчилгаа данстай холбоотой

Илрүүлэлт 1: Тайлант онд Монгол банкны мэдээллийн санд авлага болон урьдчилгааг иргэн бүрээр гадаад валютаар илэрхийлэн нийлүүлсэн боловч НБББББ-ийн дагуу ханшийн тэгшитгэл хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4. үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан

нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-ийн дагуу гадаад валютаар илэрхийлэгдэх авлага болон урьдчилгаа дансны үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийх.

Зардалтай холбоотой

Илрүүлэлт 2: Тус байгууллага нь СБД-ийн 1-р хороо, Сав плазагийн 11 дүгээр давхрын 320.99 м² оффисын талбайг түрээслэх гэрээг байгуулахдаа 1 м² талбайн сарын түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан дүнгээс 8.2 мянган төгрөгөөр өндөр дүнгээр тохиролцож, нийт 28,777.9 мянган төгрөгийн илүү зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх байр талбайн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн бусдаас түрээслэх 1 м.кв талбайн 1 сарын түрээсийн төлбөрийн дээд хязгаарыг Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 50.0 мянган төгрөгөөр тогтоосугай" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны төсвийн захирагчид түрээсийн зардалтай холбоотой харьцуулсан судалгаа, төрийн өмчийн байранд нүүх боломжтой талаар санал хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 284,554.3 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	284,554.3	-	-	1	284,554.3	1	284,554.3	-	-	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олзыг 6,272.1 мянган төгрөгөөр дутуу, Гадаад валютын ханшийн зөрүүний гарзыг 2,151.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	8,423.8	-	-	1	8,423.8	1	8,423.8	-	-	-	-
Санхүүгийн байдлын тайлангийн тайлант үеийн үр дүнг, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүнгээс 2,071.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	2,071.5	-	-	1	2,071.5	1	2,071.5	-	-	-	-
Дүн	3	295,049.6	-	-	3	295,049.6	3	295,049.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрийн 2025-2026 оны хичээлийн жилд Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах 258 оюутанд 9,317,466.8 мянган төгрөгийг гэрээ байгуулаагүй олгосон байна.	1	9,317,466.8	-	-	1	9,317,466.8	-	-
Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/480, 2023 оны А/408 дугаар тушаалын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд гадаадад суралцаж байсан 7 суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тул санхүүжилтийг зогсоосон боловч тус суралцагчидтай тооцоо нийлж, эргэн төлүүлэх графикийг үйлдээгүй. Эдгээр суралцагчдад дотоодын бэлтгэл хөтөлбөрт 30,441.3 мянган төгрөг, сургалтын төлбөр, дотуур байрны төлбөр, амьжиргааны зардалд 1,108,237.8 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.	1	1,138,679.1	-	-	1	1,138,679.1	-	-
Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтаагүй University of latin American, Istanbul Technical University сургуулиудаас хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй хүний их эмч болон сүлжмэлийн инженер мэргэжлээр тус тус урилга авсан 2 иргэний сонгон шалгаруулж, 23,841.5 мянган төгрөгийн тэтгэлэг олгогдсон байна. Энэ нь сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэгтэй ажлын албаны дэргэдэх орон тооны бус зөвлөлөөс зохих хяналтыг тавьж ажиллаагүй байна.	1	23,841.5	-	-	1	23,841.5	-	-
Наргил шийдэл ХХК-тай 46,623.5 мянган төгрөгийн мэдээллийн технологийн шийдлийг бүтээх, зөвлөгөө өгөхөөр хамтран ажиллах гэрээг 2020 онд байгуулсан боловч одоог хүртэл гэрээг бүрэн дүгнээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	46,623.5	-	-	1	46,623.5	-	-

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант онд Монгол банкны мэдээллийн санд авлага болон урьдчилгааг иргэн бүрээр гадаад валютаар илэрхийлэн нийлүүлсэн боловч НБББББ-ийн дагуу ханшийн тэгшитгэл хийгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Тус байгууллага нь СБД-ийн 1-р хороо, Сав плазагийн 11 дүгээр давхрын 320.99 м ² оффисын талбайг түрээслэх гэрээг байгуулахдаа 1 м ² талбайн сарын түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын 2024 оны 139 дүгээр тогтоолоор баталсан дүнгээс 8.2 мянган төгрөгөөр өндөр дүнгээр тохиролцож, нийт 28,777.9 мянган төгрөгийн илүү зардал гаргасан байна.	1	28,777.9	-	-	-	-	1	28,777.9
Ажлын албаны даргын 2024 оны Б/23 дугаар тушаалыг үндэслэн чөлөөлөгдсөн ажилтанд дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 12,571.8 мянган төгрөгийг урсгал зардлаас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг тайлант онд авч ажиллаагүй.	1	12,571.8	-	-	1	12,571.8	-	-
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж 46,680.0 мянган төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн байна.	1	46,680.0	-	-	1	46,680.0	-	-
Дүн	8	10,614,640.6	-	-	6	10,585,862.7	2	28,777.9

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тус ажлын алба нь сангийн хөрөнгөөр суралцсан төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгааг 2025 оны байдлаар гаргаагүй, суралцагч, төгсөгчийг дэмжих зорилгоор ажил олгогчидтой уулзах өдөрлөгийг заасан хугацаанд зохион байгуулаагүй, ажлын байрны захиалгын сан бүрдүүлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Боловсролын зээлийн сангийн ажлын албаны дарга нь ЗГ хоорондын гэрээний дагуу МУ-аас гадаад улсад 2025-2026 оны хичээлийн жилд суралцах хүсэлтэй иргэдийн сонгон шалгаруулах, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад буцалтгүй тусламжаар суралцах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг ахалсан нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-
Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч нь тайлант онд дээд шатны төсөв захирагчаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан боловч Төсвийн тухай хуульд заасны дагуу үр дүнгийн гэрээ байгуулаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Засгийн газрын 2021 оны “Боловсролын зээлийн сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 264 дүгээр тогтоолоор ажлын албаны орон тооны хязгаарыг 32 байхаар тогтоосон бөгөөд 2025 онд 13 албан хаагч шинээр томилогдож, 8 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөнийг нийт орон тоонд харьцуулахад 25 хувь нь чөлөөлөгдөж, 40.6 хувь нь шинээр томилогдсон	1	-	-	-	-	-	1	-

Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

үзүүлэлтээс дүгнэхэд ажлын албанд хүний нөөцийн бодлого сул хэрэгжиж, шилжилт хөдөлгөөн өндөр байгаа нь хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой байх зарчим алдагдаж улмаар төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, үр нөлөөтэй хүргэхэд эрсдэл учруулж байна.								
Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2025 оны А/90 дүгээр тушаалаар Албан тушаалын тодорхойлолтыг батлахдаа зарим ажлын байрны чиг үүрэгтэй уялдуулахгүйгээр “мэргэжил” гэсэн шаардлагад олон төрлийн мэргэжлийг тусгасан байна.	1	-	-	-	-	-	1	-
Ажлын алба нь тайлант оны III, IV улиралд тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжаар суралцаж байгаа суралцагчдын гэрээг хугацаанд нь дүгнэж, үнэлээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Ажлын алба нь захиргааны үйл ажиллагаанаас бусад баримт бичгийг цахим хэлбэрээр архив үүсгээгүй, мөн суралцагчдын хувийн хэргийг журмын дагуу цахимжуулж хадгалаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	7	-	-	-	-	-	7	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 675/А0171245

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА - СТА - ЗГТС

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэгтэй ажлын албаны дэргэдэх орон тооны бус зөвлөлөөс зохих хяналтыг тавьж ажиллаагүйгээс Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтаагүй University of latin American, Istanbul Technical University сургуулиудаас хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн жагсаалтад ороогүй хүний их эмч болон сүлжмэлийн инженер мэргэжлээр тус тус урилга авсан 2 иргэнийг сонгон шалгаруулж, 23,841,497.80 /Хорин гурван сая найман зуун дөчин нэгэн мянга дөрвөн зуун ерэн долоон төгрөг наян мөнгө/ төгрөгийн тэтгэлэг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны "Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай" 78 дугаар зарлигийн 1-д "Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн эхний 20-д багтсан сургуульд суралцагчид хүсэлтийг нь үндэслэн суралцаж буй мэргэжлийн чиглэлийг харгалзахгүйгээр санхүүжилт олгох", 2-т "Дэлхийн шилдэг их сургуулийн зэрэглэлийн 21-100-д багтсан сургуульд суралцагчид Монгол Улсын Засгийн газраас зарласан мэргэжлийн чиглэлийг харгалзан хүсэлтийг нь үндэслэн санхүүжилт олгох", Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл батлах тухай" 115 дугаар тогтоол "хавсралт 1-д заасан мэргэжлийн чиглэл", Боловсролын зээлийн сангийн ажлын албаны даргын 2024 оны А/48 дугаар тушаалаар баталсан "Орон тооны бус зөвлөлийн ажиллах дүрмийг батлах тухай" тушаалын 2.9.1-д "сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих чиг үүрэгтэй ажлын албаны дэргэдэх орон тооны бус зөвлөлөөс дүрэмд заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны даргын албан үүргийг гүйцэтгэгч /М.Төртогтох/, Гадаад зээл, тэтгэлгийн хэлтсийн дарга /С.Анхбаяр/, Ажлын албаны дэргэдэх орон тооны бус зөвлөлд тус тус даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Ц.Наранчимэг
С.Нацагдорж
Г.Оюунтөгөлдөр
Д.Батчимэг
Э.Булганчимэг

8004103
9025281411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 676/АД171245

Улаанбаатар хот

САГ-2026/3/КА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын албаны даргын 2024 оны Б/23 дугаар тушаалыг үндэслэн чөлөөлөгдсөн ажилтанд дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр 12,571,790.00 /Арван хоёр сая таван зуун далан нэгэн мянга долоон зуун ерэн/ төгрөгийг байгууллагаас төлсөн боловч төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг тайлант онд авч ажиллаагүй.


Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 4.2.9. энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрд учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын яамны салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Л.Төгсбаяр/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Д.БАТЧИМЭГ
Э.БУЛГАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga.2026.0316.SAG-27.Docx

1526180836



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 677/A0171245

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА - СТА - ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Наргил шийдэл ХХК-тай 46,623,500.00 /Дөчин зургаан сая зургаан зуун хорин гурван мянга таван зуун/ төгрөгийн мэдээллийн технологийн шийдлийг бүтээх, зөвлөгөө өгөхөөр хамтран ажиллах гэрээг 2020 онд байгуулсан боловч одоог хүртэл гэрээг бүрэн дүгнээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээг бүрэн дүгнээгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахгүй байгаа зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны даргын албан үүргийг гүйцэтгэгч /М.Төртогтох/, санхүүгийн хэлтсийн дарга /Х.Цэнджав/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Д.БАТЧИМЭГ
Э.БУЛГАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-26 230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAC-27.Docx

1526180834



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 678/А0171245

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлгээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/480, 2023 оны А/408 дугаар тушаалын дагуу 2024-2025 оны хичээлийн жилд гадаадад суралцаж байсан 7 суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тул санхүүжилтийг зогсоосон боловч тус суралцагчидтай тооцоо нийлж, эргэн төлүүлэх графикийг үйлдээгүй байна. Эдгээр суралцагчдад дотоодын бэлтгэл хөтөлбөрт 30,441,348.00 /Гучин сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга гурван зуун дөчин найман/ төгрөг, сургалтын төлбөр, дотуур байр, амьжиргааны зардалд 1,108,237,814.73 /Нэг тэрбум нэг зуун найман сая хоёр зуун гучин долоон мянга найман зуун арван дөрвөн төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийн санхүүжилт олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Иргэний хуулийн 227 дугаар зүйлийн 227.1-д "Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй", Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2022 оны А/544, А/256 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Гадаадад суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгох гэрээ"-ний 2.2.3-т "Санхүүжилт олгох хугацаанд хамаарах дүнгийн мэдээллийг хичээлийн жилийн улирал бүрийн эхэнд тухайн оронд суугаа Монгол Улсын Элчин сайдын яам болон Санд хүргүүлнэ" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргээ биелүүлээгүй 7 суралцагчидтай тооцоо нийлж, эргэн төлүүлэх хуваарийг үйлдээгүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны даргын албан үүргийг гүйцэтгэгч /М.Төртогтох/, санхүүгийн хэлтсийн дарга /Х.Цэнджав/, Гадаад зээл, хэлтсийн дарга /С.Анхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Д.БАТЧИМЭГ
Э.БУЛГАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 679/АД171245

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА -СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хичээлийн жилд суралцах 258 оюутанд 9,317,466,786.55 /Есөн тэрбум гурван зуун арван долоон сая дөрвөн зуун жаран зургаан мянга долоон зуун наян зургаан төгрөг тавин таван мөнгө/ төгрөгийг гэрээ байгуулаагүй олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна", Засгийн газрын 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам"-ын 4.15-д "Сан бэлтгэл хөтөлбөрт шалгарсан суралцагч болон суралцах сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, үндсэн хөтөлбөрийн суралцагч болон түүний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ, энэ журмын 4.2.2-т заасан суралцагчтай хоёр талт гэрээг тус тус байгуулна", 11.1-д "Сан нь суралцагчтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулна. Суралцагчтай байгуулах гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална", 11.2-т "Суралцагчтай байгуулах гэрээг хичээлийн улирлын үргэлжлэх хугацаагаар байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана: 11.2.2. зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хэмжээ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8 "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230


Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-27.Docx

1526180828

1. Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2025-2026 оны хичээлийн жилд суралцах 258 оюутантай гэрээ байгуулалгүй тэтгэлэг олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны даргын албан үүргийг гүйцэтгэгч /М.Төртогтох/, санхүүгийн хэлтсийн дарга /Х.Цэнджав/, Гадаад зээл, тэтгэлгийн хэлтсийн дарга /С.Анхбаяр/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
С НАЦАГДОРЖ
Г ОЮУНТӨГӨЛДӨР
Д БАТЧИМЭГ
Э БУЛГАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 680/A0171245

Улаанбаатар хот

САГ-2026/3/НА-СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын зээлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж 46,680,000.00 /Дөчин зургаан сая зургаан зуун наян мянга/ төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3-т "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулахгүйгээр төсөвт өртгийг хувааж шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны даргын албан үүргийг гүйцэтгэгч /М.Төртогтох/, санхүүгийн хэлтсийн дарга /Х.Цэнджав/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Д.БАТЧИМЭГ
Э.БУЛГАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-27.Docx

1526180838